

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хэдийгээр би хилийн чанадад багш сонгон шалгаруулах ажлаар явж байгаа ч манай удирдлагын багийнхан болон багш нар миний эзгүйд сурагчидтайгаа сайн ажиллаж байгааг та бүхэнд дуулгахад таатай байна. Сургууль дээр олон арга хэмжээ зохиогдож 4-р ангийн сурагчид зуданд нэрвэгдсэн малчдад туслах хөдөлгөөн өрнүүлж, ACAMIS сагсны тэмцээнд охид хөвгүүдийн багууд маш амжилттай оролцож, хэсэг сурагчид Катарт MUN хуралдаанд оролцоод ирлээ.

Дунд сургуулийн хөтөлбөрийн зохицуулагч Mr. David Chilton эцэг эхчүүдэд зориулж МҮР хөтөлбөрийн хүрээнд сурагчдын мэдлэгийг ямар үзүүлэлтүүдээр хэрхэн дүгнэдэг талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийсэнд баяр хүргэе. Бид олон эцэг эхчүүдийг ирж энэхүү мэдээллийг аваасай гэж найдаж байсан. Гэхдээ энэ арга хэмжээнд хүрэлцэн ирсэн эцэг эхчүүд үнэтэй, чухал мэдээлэл олж авсан гэдэгт итгэлтэй байна.

Захирал Greg Rayl

Хуанлид Тэмдэглэх Өдрүүд:

2 сарын 12	Цагаан Сарын Өдөрлөг-8:30
2 сарын 15, 16	Цагаан Сарын амралт, Хичээл орохгүй
2 сарын 18	Дунд Сургуулийн Эцэг Эх Багш нарын хурал
2 сарын 23	ЭББ-ийн хурал-19:00 цагт
3 сарын 5	Бага Сургуулийн сурагчид кино үзнэ
3 сарын 18	Бага Сургуулийн сурагчдын хөгжимт жүжгийн тоглолт

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Өнгөрсөн долоо хоногийн амралтын өдрүүдэд Бээжинд болсон ACAMIS сагсны тэмцээнд манай сургуулийн охид, хөвгүүдийн баг амжилттай оролцож хоёр баг хоёулаа 2-р байр эзэлсэн. Та бүхэн манай тамирчдад баяр хүргээрэй. Манай Охидын баг шилдэг багийн шагнал авсан. Сурагчдын хувьд тэмцээнд оролцож түрүүлэхээс илүү амжилттай оролцох нь чухал байдаг. Манай тамирчид шилдэг багаар зүй ёсоор сонгогдсонд бид бахархаж байна.

МҮР хөтөлбөрийн хүрээнд сурагчдын мэдлэгийг хэрхэн үнэлдэг талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн хөтөлбөрийн зохицуулагч Mr. David Chilton-д баяр хүргэе. Бид Монгол, Солонгос хэл дээр орчуулга хийсэн бөгөөд энэ арга хэмжээнд ирж оролцсон эцэг эхчүүд их зүйлийг сурч авсан.

6-12-р ангийн сурагчдын дүн гарч багш нар маань сурагчдын дүнг нэгтгэсэн тайлан бичээд завгүй байна. Та бүхэн хүүхдийнхээ сурлагын дүнтэй танилцаж сайтар уншаад тэдэнтэй дүнгийх нь талаар ярилцаарай. ОУДС-д хүүхэд тань юу сурч байгаа талаар та бүхэн мэдэж байх нь чухал. Хүүхэд тань ч та бүхнийг өөрсдийнх нь хичээл сурлаганд анхаарч оролцож байгааг мэдэх нь бас чухал. Эцэг эх, Багш, Сурагчдын гурвалсан холбоо сайн хамтран ажиллаж байж хүүхэд тань амжилттай суралцах болно. Манай багш нартай та бүхэн е-мэйлээр харилцах боломжтой. Багш нарын хаягийг манай вэб сайтаас аваарай. Та бүхэнд асууж лавлах зүйл байвал шууд багш нартай нь буюу надтай холбоо бариарай.

Бид нар сургалтын шилдэг орчин бүрдүүлэхийн төлөө та бүхэнтэй хамтран ажиллахдаа баяртай байх болно. Хэрвээ та бүхэн цаг авч багш нартай уулзах хүсэлтэй бол сургуулийн ресепшин Халиунаа/Ms. Annie-тэй утсаар холбогдож цаг аваарай. Ирэх долоо хоногийн Баасан гарагт манай сургуулийн цагаан сарын өдөрлөг болно. Та бүхэн хүрэлцэн ирж манай өдөрлөгийг сонирхоорой. Өнөөдөр та бүхэн хүүхдийнхээ сурлагын дүнтэй танилцаад дүнгий нь уншиж танилцсан тухайгаа баталгаажуулж гарын үсгээ зураад хуудсыг буцааж анги удирдсан багшид нь ирүүлээрэй. Баярлалаа.

**Дунд Сургуулийн Эрхлэгч
Betsy Hanselmann**

Лхагва гарагт манай 5 сурагч Катарт жил бүр уламжлал болон явагддаг MUN (НҮБ)-н хуралдаанд оролцоод ирлээ. Доха хотын Marriott зочид буудалд болсон энэхүү хуралдаанд бид 2 дахь удаагаа амжилттай оролцлоо. Тэнд байх хугацаандаа сурагчид маань Исламын уран зургийн музей урилгаар үзэж Georgetown сургуульд зочилж дэлгүүр орж өөрсдийн хэрэгцээт зүйлсийг худалдан авсан. Энэ жил манай гурван сурагч Иорданы төлөөлөгчид болж хоёр сурагч CNN, BBC-н хэвлэлийн

төлөөлөгчдөөр ажиллаа. Энэ арга хэмжээнд оролцсоноор сурагчид маань их олон зүйлийг сурч мэдэж цагийг бас хөгжөөнтэй өнгөрөөсөн. Сурагчид маань сайн ажиллаж олон орны сурагчидтай найз нөхөд болцгоосон. Энэ арга хэмжээнд оролцоход сурагчдын хувьд нэг бэрхшээлтэй асуудал нь аялалын зардал маш өндөр байсан. Бид тэнд байхдаа бусад олон орны сурагчид энэ арга хэмжээнд оролцох зардлаа тэтгэлэг, хандив тусламжаар олж авдаг талаар мэдэж авсан. Ирэх жил Катар нисэх зардлын зарим хэсгийг хандив босгож цуглуулахаар манай сурагчид төлөвлөж байна.

MUN- арга хэмжээг зохион байгуулагч Melanie Wilson

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

АНУ-ын Marine Corps-с зохион байгуулж байгаа “Toys for Tots” буяны арга хэмжээнд хандив ирүүлсэн гэр бүлийнхэндээ баярлалаа. Verbist төвийн хүүхдүүд та бүхний хандивыг баяртай хүлээн авна гэдэгт би итгэлтэй байна.

ОУДС-ийн 4-р ангийн сурагчид зуданд нэрвэгдсэн малчдад туслах хөдөлгөөн өрнүүлэх шийдвэр гаргалаа. Өнөөдөр болсон нийт сургуулийн өдөрлөг дээр тэд товчхон презентаци хийж анги тус бүр тодорхой тусламж цуглуулах боллоо. Эцэг эхчүүд та бүхэн хүүхдийнхээ ангийн хуваарилж авсан хандивын тусламж дээр дэмжлэг үзүүлээрэй. Үүнээс гадна та бүхэнд хуучин хувцас, хайрцаг байвал бидэнд хандивлаарай. Хандивын ажилд идэвхтэй оролцсон анги гэнэтийн бэлэг хүлээн авах болно. 4-р ангийнхандаа баярлалаа.

Багш нар маань “Charlie and the Chocolate Factory” тоглолтондоо бэлтгээд завгүй байна. Бид сурагчиддаа гэрийн даалгавраас гадна гэртээ давтах жүжгийн үгийг нь өгч явуулж байгаа. Та бүхэн жүжгийн үгээ давтахад нь хүүхдүүддээ туслаарай. Жүжгийн бэлтгэл ажилд туслах хүсэлтээ илэрхийлсэн эцэг эхчүүдийн уулзалт 2 сарын 8-ны Даваа гарагт 5-р ангийн өрөөнд болно. Тоглолтын бэлтгэл ажилд туслах хүсэлтэй эцэг эхчүүд байвал Ms. Carroll-той холбоо барина уу.

1-р семестрийн дүнг бид өнөөдөр гэрт нь сурагчдаар өгч явуулсан. Та бүхэн хүүхдийнхээ дүнг хүлээж авсанаа баталгаажуулж гарын үсэг зурсан хуудсаа ангийн багшид нь буцааж ирүүлнэ үү. Математикийн хичээлийн дүн дээр хэд хэдэн N/A (not assessed) буюу үнэлэгдээгүй гэж бичигдсэн байгаа учир нь Математикийн хичээлийн хөтөлбөрийн дагуу ихэнх сэдвүүдийг 2-р семестрт судалж дүгнэдэг.

Өдөрлөг: Пүрэв гарагт “Choral Poetry” өдөрлөг зохиосон 3-р ангийн сурагчиддаа баярлалаа. Хүний дотоод мэдрэмж, сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн яруу найргуудыг тэд сонгосон байлаа. Өдөрлөгийн дараа тэд өөрсдийгөө хэрхэн илэрхийлэх вэ сэдвийн дагуу зурсан бүтээлүүдээ эцэг эхчүүдэд сонирхууллаа.

**Бага Сургуулийн Эрхлэгч
Jan Wiggins**